

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014
оны 7 дугаар сарын 30-ны өдрийн
А-122 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛБАНК

ВАЛЮТЫН ЗЭЭЛ ХҮССЭН ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХҮРГҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтдог тул валютаар зээл авах нь төгрөгийн зээлээс хүүгийн хувьд хямд хэдий ч ханшийн эрсдэлтэй байдаг. Ханшийн эрсдэлийг дутуу үнэлснээс болж валютын зээлтэй иргэд, аж ахуйн нэгжүүд алдагдалд орох, зээлээ эргэн төлөхөд хүндрэл учирч болзошгүй. Иймд ханшийн эрсдэл болон түүнийг бууруулах санхүүгийн үүсмэл хэрэгслийн талаарх ойлголтоо нэмэгдүүлэх, төгрөгийн зээлийг сонгох, валютын зээл зайлшгүй авах шаардлагатай бол санхүүгийн үүсмэл хэрэгсэл (своп, форвард) ашиглан ханшийн эрсдэлээс сэргийлэхийг зөвлөж байна.



МОНГОЛБАНК

Бага тойруу 3, 15160.
Улаанбаатар, Монгол
Факс: 976-11-311471
www.mongolbank.mn



МОНГОЛБАНК

ВАЛЮТЫН ЗЭЭЛ ХҮСЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Та гадаад валютын зээл сонирхож байгаа бол энэхүү гарын авлагатай сайтар танилцана уу! Учир нь эрсдэлийг тооцоололгүйгээр валютын зээл авснаар алдагдалд орох, зээлээ эргэн төлөхөд хүндрэл учирч болзошгүй юм.

УЛААНБААТАР ХОТ
2014



Валютын зээл

ЗЭЭЛ АВАХААС ӨМНӨ ТАНЫ МЭДЭХ ЁСТОЙ ЗҮЙЛ

Ам.доллар, юань, евро гэх мэт гадаад валютаар зээл авах нь хүүгийн хувьд өнгөц харахад төгрөгийн зээлээс хямд бөгөөд ашигтай харагдаж болно. Гэвч валютын зээл нь валютын ханшийн өөрчлөлтөөс шууд хамаардаг тул таны сар бүр эргэн төлөх төлбөр өсч болзошгүй бөгөөд энэ талаараа эрсдэл өндөртэй санхүүгийн бүтээгдэхүүнд тооцогддог.

САНАМЖ

1. ДАН ГАНЦ ЗЭЭЛИЙН ХҮҮНД АНХААРЛАА БҮҮ ХАНДУУЛ.
2. ВАЛЮТЫН ЗЭЭЛ НЬ ХАНШИЙН ЭРСДЭЛТЭЙ.
3. САР БҮР ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРӨӨ ТӨЛӨХ ЧАДВАРТАЙ ЭСЭХЭЭ НАРИЙН ТООЦООЛ.
4. ЭРСДЭЛИЙН ТАЛААР ОЙЛГОЛТГҮЙ БОЛ ВАЛЮТЫН ЗЭЭЛ БҮҮ АВ.
5. ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ НЬ ХАНШИЙН ЭРСДЭЛГҮЙ.
6. ТА ВАЛЮТЫН ОРЛОГОГҮЙ БОЛ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ НЬ ТАНД ИЛҮҮ ТОХИРОМЖТОЙ.



Дүрсэл 1-ээс харахад төгрөгийн зээлийн төлбөр сар бүр тогтмол байгаа бол ам.долларын зээлийн төлбөр валютын ханшаас хамаарч нэмэгдсэн дүр зураг харагдаж байна. Хүснэгт 1-ийн жишээгээр валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж валютын зээл нь илүү өртөгтэй болсон байна.

Валютын зээл = Эрсдэлтэй санхүүжилтын арга хэрэгсэл !

ГАДААД ВАЛЮТЫН ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Валютын зээлийн хүү нь төгрөгийн зээлийн хүүгээс бага байдаг боловч валютын зээл нь хямд гэсэн үг биш юм. Учир нь валютын ханшийг урьдаас тааварлах боломжгүй тул таны сард төлөх зээлийн төлбөр валютын ханшаас хамаарч өөрчлөгдөнө. Хэрэв төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларвал таны сард төлөх төлбөр төгрөгөөр өсөх болно. Тус өсөлт нь таны сарын орлогыг ч давах боломжтой.

ГАДААД ВАЛЮТЫН ЗЭЭЛ: ЭРСДЭЛ ӨНДӨР

- Харьцангуй бага хүү
- Сар бүрийн төлбөр валютын ханшаас хамааралтай
- Зээл үрт хугацаандаа илүү өндөр өртөгтэй болж болзошгүй.

ЭРСДЭЛ ӨНДӨР



ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ

Хэрэв та төгрөгөөр зээл авбал таны сард төлөх төлбөр тогтмол байна. Сар бүрийн зээлийн төлбөр валютын ханшаас хамаарч өөрчлөгдөхгүй.



ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ: ЭРСДЭЛ БАГА

- Харьцангуй өндөр хүү
- Сар бүрийн зээлийн төлбөр валютын ханшаас хамаарахгүй
- Сар бүрийн зээлийн төлбөр тогтмол

ЭРСДЭЛ БАГА



ХҮСНЭГТ 1. ГАДААД ВАЛЮТЫН ЗЭЭЛ, ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

	Гадаад валютын зээл	Төгрөгийн зээл
Алхам 1. Зээлийн нөхцөл		
1. Зээлийн хэмжээ	1,000,000 MNT	1,000,000 MNT
2. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш	1,392 MNT/USD	
3. Гадаад валютаар илэрхийлсэн зээлийн хэмжээ	1,000,000 / 1,392 = 718 USD	
4. Зээлийн хугацаа	12 сар	12 сар
5. Зээлийн хүү (жилийн)	13.6 %	18.9 %
Алхам 2. Сар бүрийн төлбөр		
6. Сар бүрийн үндсэн төлбөр (3/4)	718 / 12 = 60 USD	83,333 MNT
7. Сарын дундаж хүүгийн төлбөр	4.3 USD	8,522 MNT
8. Сар бүрийн төлбөр (ам.доллараар) (6+7)	64.3 USD	
9. Сар бүрийн төлбөр (төгрөгөөр) (3x8)	64.3 x 1,392 = 89,505 MNT	91,855 MNT
Алхам 3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан тохиолдолд сар бүрийн төлбөр		
10. Төгрөг 20%-иар суларсан тохиолдолд сар бүрийн зээлийн төлбөр (төгрөгөөр)	89,505 x 1.2 = 107,406 MNT	
11. Төгрөг 25%-иар суларсан тохиолдолд сар бүрийн зээлийн төлбөр (төгрөгөөр)	89,505 x 1.25 = 111,881 MNT	
Алхам 4. Зээлийн нийт зардал		
12. 6 сарын дараа валютын ханш 25 хувиар суларсан тохиолдолд	$\frac{1}{2} \times 12 \times 94,614 = 537,030$ $\frac{1}{2} \times 12 \times 111,881 = 671,287.5$ = 1,208,317 MNT	12 x 91,855 = 1,102,260 MNT

ДҮРСЛЭЛ 1. ГАДААД ВАЛЮТЫН ЗЭЭЛ, ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН САР БҮРИЙН ТӨЛБӨР

